



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/205

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Оюуны спортыг дэмжих, иргэдийн оюуны алжаалыг тайлах, хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх зорилгоор “Ховд-2022” даамны улсын аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг зохион байгуулах зардалд 8,550,000 төгрөгийг хавсралтаар баталж дэмжлэг үзүүлсүгэй.

2. Тэмцээнд зарцуулагдах 8,550,000 төгрөг (найман сая таван зуун тавин мянга)-ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.4.3-д тусгагдсан “Спортын аварга” арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дүгээр сарын 19-ний өдрийн
А/205 дугаар захирамжийн
хавсралт

“ХОВД-2022” ДААМНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Дэмжлэг өгөх хүн	Тоо ширхэг	Зарцуулагдах төсөв /мянган төгрөгөөр/
Эрэгтэй			
1	Тэргүүн байр	1	700 000
2	Мөнгөн медаль	1	500 000
3	Хүрэл медаль	1	300 000
4	Тусгай байр 4	1	200 000
5	Тусгай байр 5	1	100 000
Эмэгтэй			
6	Тэргүүн байр	1	500 000
7	Мөнгөн медаль	1	400 000
8	Хүрэл медаль	1	300 000
9	Тусгай байр 4	1	150 000
10	Тусгай байр 5	1	100 000
11	Хүүхдийн тэмцээний зардал	1	1 880 000
Бэлтгэл арга хэмжээ			
12	Ширээний цаг	10	1 000 000
13	Даамны буурь	40	200 000
14	Медаль	6	90 000
15	Өргөмжлөл	6	180 000
16	Анонс хэвлүүлэх	1	180 000
17	Шүүгчийн хөлс	4	320 000
18	Хоолны зардал	100	1 450 000
НИЙТ			8 550 000